

## 8

### ТАТВАРЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

С.Баатар, Ч.Энхбаяр

*Төр оршихуй дор татвар буй  
Татвар оршихуй дор төр буй*

Төрийг татваргүйгээр, татварыг төргүйгээр төсөөлөх боломжгүй билээ. Төр оршин тогтнож эдийн засгийн хөгжлийг зохицуулдаг ерөнхий зүй тогтол бий боловч, төрийн бодлого нь төсөвт тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг дайчлан зарцуулахгүйгээр хэрэгжихгүй гэдэг нь ойлгомжтой юм.

Ер нь эдийн засгийн хөгжлийг зохицуулдаг хоёр гол механизм бий. Үүнд:

- Адам Смитийн “үл үзэгдэгч гар” буюу зах зээлийн өөрийнх нь механизм;
- Кейнсийн боловсруулсан онол буюу төрийн зохицуулалтын механизм.

Төрийн зохицуулалт зайлшгүй байх шаардлага нь зах зээлийн өөрийнх нь механизмаар зохицуулах боломжгүй эдийн засаг болон нийгмийн дэд (зам, харилцаа холбоо, эрчим хүч, эмнэлэг, сургууль, батлан хамгаалах салбар, нийгмийн хангамж) санхүүжилт, мөн тухайн үеийн (үйлдвэрлэлийн уналтыг сэргээх, санхүүгийн тогтолцоог боловсронгуй болгох, ажилгүйдэл, ядуурал, инфляцийг бууруулах) тулгамдсан хурц асуудлуудыг шийдвэрлэх гээд үй түмэн зохицуулалтыг төр хариуцаж байдагтай холбоотой.

Төрийн зохицуулалтыг зах зээлийн өөрийнх нь механизм, зарчимтай оновчтой хослуулан хэрэглэж чадсан орон амжилт олж, үр дүнд хүрдгийг хөгжингүй улс орнуудын

бодит туршлага харуулж байна. Өөрөөр хэлбэл, зах зээлийн өөрийнх нь механизм, төрийн зохицуулалт хоёр нэг нь нөгөөгийнхөө дутагдалтай талыг харилцан нөхөж хосолж чаддаг гэсэн үг юм. Зах зээл өөрийн хөгжлийн зүй тогтолтой. Түүнд төрөөс оролцож зохицуулахын хэрэггүй гэдэг ойлголт 1960-аад онд үндсэндээ төгсгөл болжээ. Зарчмын хувьд төрийн өмчийн бус компаниудын ажилд төрөөс оролцохыг хатуу хориглож, төрийн зохицуулалтыг зөвхөн макро түвшинд хэрэгжүүлэх нь зөв гэж үздэг.

Эдийн засгийн макро түвшний зохицуулалтыг хийхэд Засгийн газарт мөнгө хэрэгтэй бөгөөд энэ мөнгөний дийлэнхийг татварын аргаар цуглуулдаг зах зээлийн улс орнуудын өнгөрсөн бөгөөд өнөөгийн практик бодит зүйл болсон байна.

Хөгжлийн тодорхой үе шатуудад татварын талаарх онолын үзэл, баримтлалыг эрдэмтэд, судлаачид тайлбарласаар ирсэн байна. Татварын онолын үзэл баримтлалуудын хувьсал нь эдийн засгийн сэтгэлгээний урсгалуудын хөгжилтэй нэгэн зэрэг явагдаж байдаг.

Ингээд татварын онолын үзэл баримтлалуудын талаар товч тайлбарлая.

- XVIII зууны үед Адам Смит татварын онолыг судалж, судалгааныхаа үндсэн дээр "... татвар төлнө гэдэг бол хэн нэгэнд боолчлол бус, харин эрх чөлөө байх ёстой, ингэж ойлгох нь чухал юм" гэдгийг онцолжээ.

Адам Смитийн хувьд татварын хувь хэмжээг оновчтой тогтоох нь чухал байв. Татвар оногдуулах асуудлыг төгс оновчтой шийдвэрлэсэн улс орон хараахан үгүй байна. Адам Смит 1776 онд бичсэн "Ард түмний баялгийн шалтгаан ба байгалийн тухай шинжлэх нь" номондоо татвар оногдуулалтын талаар дараах 4 үндсэн зарчим байж болохыг авч үзсэн нь өнөөгийн практикт ч хэрэглэгдсээр байгаа юм. Үүнд:

**Нэгдүгээрт, шударга байх зарчим:** Энэ зарчмын гол агуулга нь аливаа орлого олж буй субъект бүр татвар төлөгч байна. Татварыг олсон орлогынх нь хэмжээнээс хамааруулан оногдуулах нь зүйтэй юм гэдгийг хэлсэн байдаг.

**Хоёрдугаарт, тодорхой байх зарчим:** Энэ зарчмын гол агуулга нь тухайн төрлийн татварыг хэдийд, ямар хувь хэмжээгээр, ямар аргаар авах вэ? гэдэг нь татвар төлөгчдөд ойлгомжтой байх ёстой гэдгийг тайлбарласан.

**Гуравдугаарт, харгалзан үзэх зарчим:** Энэ зарчим ёсоор татварыг оногдуулахдаа татвар төлөгчдөд ашигтай байж болох тийм арга болон хугацааг сонгох нь үр дүнгээ өгөх боломжтой гэж үзжээ.

**Дөрөвдүгээрт, эдийн засгийн хувьд үр ашигтай байх зарчим:** Энэ зарчмын гол агуулга нь татварт цуглуулахад гарч буй үр ашиггүй аливаа зардлуудыг бууруулахад чиглэгдэнэ.

Адам Смитийн дараа сонгодог урсгалын төлөөлөгчид болох У.Петти, Д.Рекардо, Дж.

Милль нар улс орон хөгжлийн өндөр түвшинд хүрсэн үед татвар оногдуулалтыг төгс шийдвэрлэх боломжтой юм гэж үзсэн байдаг.

Сонгодог урсгалын дараагаар онолын шинэ урсгалууд бий болов.

- Макро түвшинд эдийн засгийн өсөлтийг хангахад чиглэсэн, найдвартай зохицуулалт төрийн зүгээс хийх шаардлагатай гэдгийг Дж.М.Кейнс өөрийнхөө бүтээлд тусгасан байна. Энэ талаар Кейнс жирийн эрэлт биш, жинхэнэ үр ашигтай эрэлт гэж бүтээлдээ олонтаа тэмдэглэсэн байдаг. Үр ашигтай эрэлт гэдэг нь эдийн засаг бүрэн ажил эрхлэлтийнхээ орчинд орсон үед л ажиглагддаг бөгөөд ийм нөхцөл бүрдвэл төр оролцож байж ажил эрхлэлтийг ахиулах юм. Кейнс аль ч орны ажиллах хүчний 80-90 хувийг ажлаар хангана гэдэг бол амархан. Ингэхийн тулд хувийн секторын хүчээр ажилгүйдлийг бууруулж, ажил эрхлэлтийг дээд цэгтээ ойртсон тэр үед л төрөөс оролцож ажлын байр бий болгох учиртай. Төр бол ажил олгогч биш гэдгийг хэлсэн байдаг. Дж.М.Кейнс 1936 онд бичсэн "Мөнгө, хүү, ажил эрхлэлтийн онол" номондоо зөвхөн бүрэн ажил эрхлэлтийн үед л хангалттай хуримтлалтай байх, ингэснээр эдийн засгийн өсөлтийг бий болгох боломжтой гэдгийг судалгааныхаа ажлын үр дүнгээр тайлбарласан байна. Японы эдийн засаг түргэн хурдацтай хөгжихөд Дж.М.Кейнсийн онол тодорхой үүрэг гүйцэтгэсэн байна. Тухайлбал, хувь хүмүүс хэрэглээнийхээ 18-20 хувийг хуримтлалд зориулдаг байна. Хүмүүс мөнгөө хуримтлуулах сонирхолтой байдаг нь хадгаламжийн хүү өндөр байдагтай холбоотой ба үүнийг хуримтлал бий болгох хөшүүрэг ч гэж үздэг.

Дж.М.Кейнс зөвхөн чөлөөт зах зээлийн тогтолцоо зүгширсэн үед төрөөс оролцож, эдийн засгийг зохицуулах нь агуулгын хувьд зөв болохыг тайлбарласан. Түүнээс биш төр оролцвол бүх юм сайн сайхан болно гэж хавтгайруулаагүй байна. Төрийн оролцоо үр ашигтай болох тодорхой нөхцлүүд бий гэдгийг хэлсэн. Зах зээлийн механизм сайтар зүгшрээгүй байхад төрөөс эдийн засагт шууд оролцох, тэр тусмаа бизнестэй хутгалдвал эдийн засагт элдвийн зөрчлүүд үүсэж, энэ нь эдийн засгийн болоод улс төрийн тогтворгүй байдлыг бий болгодог гэж үзсэн байна.

Үүний дараагаар шинэ Кейнсчүүдийн онолын урсгалууд бий болов.

- Шинэ Кейнсчүүдийн онолын үзэл баримтлалд татварын асуудлууд нилээд чухал байрыг эзэлж байна. Энэ онолын төлөөлөгчид И.Фишер, Н.Калдор нь хэрэглээний татварыг барааны эцсийн өртөгт ногдуулах, хуримтлалд (хадгаламжид) ногдуулах татварыг зөвхөн түүний хүүд ногдуулах татварын хувь хэмжээгээр хязгаарлах замаар татварын объектыг ангилах шаардлагатай гэж үзсэн. Эндээс хэрэглээний татвар нь хуримталыг өсгөх арга болоод зогсохгүй инфляцитай тэмцэх хэрэгсэл болж өгнө гэсэн санаа гарч байгаа юм.

Түүнчлэн Н.Калдор нь тодорхой нэр төрлийн бараанд (Жишээ нь: өдөр тутмын хэрэглээний зүйлс) ногдуулах хөнгөлөлт бүхий өсөн нэмэгдэх хувь хэмжээтэй хэрэглээний татвар нь орлого багатай хүмүүст ногдуулах татвараас илүү шударга байхаас гадна орлогын татвартай харьцуулахад энэ татвар нь ирээдүйн хөрөнгө оруулалтанд шаардлагатай хадгаламжинд ногдоггүйгээрээ түүний өсөлтийг урамшуулж өгдөг гэж үзсэн байна.

- Мөн Америкийн эдийн засагч П.Самуэльсоны татварын талаарх онолын үзэл баримтлал татварын шинэчлэлд ихээхэн хувь нэмэр оруулсанд зүй ёсоор тооцогдоно.

П.Самуэльсон 1948 онд бичсэн “Зах зээлийн эдийн засгийн ухаан” номондоо бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотойгоор татварын өсөлтийн онолыг гаргаж ирсэн. Өөрөөр хэлбэл, үнэ өсөх тутам татварын хувь хэмжээ мөн л өсөх ёстой гэсэн онолын концепц дэвшүүлсэн байна. Хэрэв бүтээгдэхүүний үнийг хэт өсгөвөл эрэлт нь багасна, эргэлт нь удаашрахад хүрнэ. Бизнесийн байгууллагын гол зорилго бол ашиг олох явдал мөн гэдгийг бид мэднэ. Ийм учраас бизнес эрхлэгчид алдагдалд орохгүйн тулд бүтээгдэхүүнийхээ үнийг бууруулна.

П.Самуэльсоны онолын гол агуулга бол бүтээгдэхүүний үнэ буурснаар татварын хувь хэмжээг бууруулж болох бөгөөд ингэснээр татварын тусламжтайгаар инфляцийг бууруулах боломжтой гэж үзсэн байх юм.

- Орчин үеийн эдийн засгийн хөгжлөөрөө тэргүүлж буй орнуудын татварын онол, бодлого нь нийлүүлэлтийн эдийн засгийн онол дээр тулгуурлаж байна.

Нийлүүлэлтийн эдийн засгийн онолын гол агуулга нь татварын хувь хэмжээ аль болох нам түвшинд байх ёстой гэж үздэгээр тайлбарлагдана. Ач холбогдол нь:

**Нэгдүгээрт**, далд эдийн засгийн өсөлтийг зогсоох бодит боломж бүрдэнэ.

**Хоёрдугаарт**, ажилгүйдэл буурах магадлал ихтэй.

**Гуравдугаарт**, инфляцийг бууруулах, болж өгвөл нэг оронтой тоонд барих боломжтой болно.


**Дөрөвдүгээрт**, эдийн засгийн өсөлтийн хурдцын бууралтыг зогсооход тус тус чиглэгдэнэ гэж үздэг.

Нийлүүлэлтийн эдийн засгийн онолын агуулгын өөр нэг чиглэл нь төсвийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулалтыг бууруулахад чиглэгдэнэ гэдгийг тайлбарласан.

Нийлүүлэлтийн эдийн засгийн онолын гол төлөөлөгч нь Америкийн Өмнөд Калифорнийн их сургуулийн доктор, профессор Артур Лаффер юм.

**Татварын хувь хэмжээ ба төсвийн орлогын хамаарал**

График 1




Артур Лаффер татварын хувь хэмжээг оновчтой тогтоох нь үндэсний үйлдвэрлэлд хийгдэх хөрөнгө оруулалтыг урамшуулахад чухал ач холбогдолтой гэж үзсэн байна. Хэрэв татварын хувь хэмжээ өндөр байвал үйлдвэрлэгчид татвараас зугтаах гол шалтгаан болдог гэсэн дүгнэлтийг дээрх графикийг үндэслэн хийжээ.

Үйлдвэрлэгчид татвар төлөхийн тулд үйл ажиллагаа явуулдаггүй. Төсөвт татвар төлөөд үлдэж буй цэвэр орлого нь тухайн татвар төлөгч цааш нь ажиллах уу, эсвэл зүгээр суусан нь дээр үү гэдгийг тодорхойлж өгдөг. Хэрэв үйлдвэрлэгчдэд ирээдүйд ашиг олох боломж харагдахгүй байвал үйлдвэрлэл зогсонги байдалд орж, улмаар эдийн засаг уналтанд орно. Ийм учраас Артур Лафферийн гол үзэл баримтлал нь үйлдвэрлэгчдэд ажиллах сонирхол байвал эдийн засагт хөгжих боломж нээлттэй болохыг олон жилийн судалгааныхаа баялаг туршлага дээр үндэслэж тайлбарласанд оршино. Татварын хувь хэмжээний өсөлт нь тодорхой хязгаарт (Лафферийн муруй) төсвийн орлогын өсөлтийг бий болгоод, тодорхой хязгаараас давбал төсвийн орлогыг уналтанд оруулдаг. Өөрөөр хэлбэл, татварын хувь хэмжээ зохих түвшингээс хэтэрвэл татвар төлөгчдийн идэвх санаачлага буурч, орлого багасч, татвар төлөгчдийн тодорхой хэсэг нь хуулийн хүрээнээс хууль бус (сүүдрийн) эдийн засагт шилждэг болох нь практикт нэгэнт нотлогдсон байна.

**Татвар ногдуулалтын суурь ба эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаанд татварын хувь хэмжээний өөрчлөлтийн үзүүлж буй нөлөө**

График 2



Артур Лафферийн тооцоолсноор татварын бодитой хувь хэмжээ 30 хувь гэж үзсэн байна. Хэрэв татварын хувь хэмжээ 40 хувиас дээш бол хаалттай бүсийн татварын хувьд шилжиж, ингэснээр хуримтлал багасах, хөрөнгө оруулалт хумигдах, эдийн засаг уналтанд орох аюултай гэж тооцоолжээ.

Татвар нь төсвийн орлогыг бүрдүүлэх гол эх үүсвэр мөн боловч хөгжлийн тодорхой үе шатуудад татвар хураалт, үйлчилгээний асуудлыг боловсронгуй болгож байх нь юу юунаас чухал болно. Энэ нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг агуулсан татварын тогтолцоо аль ч улс оронд байдаг гэсэн ерөнхий зарчмаас урган гарч байна.

Бидний дээр үзсэн онолын үзэл баримтлалууд нь ямар нэг хязгаар тогтоох нь бараг боломжгүй ч татварын үйлчлэлээс үүсч болох сөрөг үр дагавраас зайлсхийх, тэдгээрийг эдийн засгийн тодорхой нөхцөл байдалд арилгаж болох бөгөөд үүний тулд эдийн засгийн хөгжил болон татварын бүтэц, төсөвт орох татварын орлогын хэмжээ зэргийн харилцан хамаарлын чиг хандлагад ажиглалт хийж болох юм гэдгийг харуулж байна.

Үр ашигтай татварын тогтолцоог бий болгоход татварын зарчмууд, мөн чанар, төрөл, хэлбэрүүдийг мэдэж байх нь хангалттай биш байдаг. Иймээс орчин үеийн татварын онолуудын судалгаа нь тодорхой, үйлчилж буй татварын системийн шинжилгээний асуудлуудын шийдвэрт тулгуурлаж байна.

Татварын онолын үзэл баримтлалууд нь түүний бодитой гэдгийг нэгэнт баталчихсан болохоор татварын системийн бүхий л давуу талуудыг улс орны эдийн засгийн хөгжлийн тодорхой үед дэвшүүлсэн зорилтуудаа хэрэгжүүлэхэд дээд зэргээр ашиглах нь чухал юм.